



ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН  
ЦАХИМ СИСТЕМ



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМ

*/ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА /*

УЛААНБААТАР ХОТ

2020 он

## Агуулга

1.	Тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрэх, бүртгүүлэх.....	4
1.1.	Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэлтэй хэрэглэгч нэвтрэх заавар.....	4
1.2.	Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэлгүй хэрэглэгч нэвтрэх заавар.....	4
1.3.	Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах байгууллагын эрх холбох тохиргоо.....	5
2.	Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар илгээх.....	6
2.1	Мэдээлэл цэс.....	7
2.2	Хүсэлт гаргах.....	10
2.3	Тусгай зөвшөөрлийн хүсэлтийн мэдээлэл.....	14
3.	Хүсэлтийн түүх.....	15
3.1	Тусгай зөвшөөрлийн илгээсэн хүсэлтийн төлөв.....	16
3.2	Улсын тэмдэгтийн хураамж төлөх нэхэмжлэх, төлөлт.....	17

## Баримтын хувилбар

Хувилбарын хяналт	Огноо	Гүйцэтгэсэн	Хийсэн өөрчлөлт
1.0	2021/01/02	Систем нэвтрүүлэлтийн алба	Эхний хувилбар
2.0	2021/08/30	Систем нэвтрүүлэлтийн алба	Системийн сайжруулалтын өөрчлөлтийг тусгасан

ААН, Иргэд цахимаар үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмших процесс зураг



# 1. Тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрэх, бүртгүүлэх


Хэрэглэгч Тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрэхийн тулд “Нэвтрэлтийн нэгдсэн систем”-ээр дамжина. Та нэг нэвтрэлтээр дараах цахим системүүдэд хандах боломжтой. Үүнд:

- Цахим татварын систем
- Бараа бүртгэлийн систем
- Төрийн албаны цалингийн систем
- Халамжийн нэгдсэн систем
- Эрүүл мэндийн даатгалын цахим систем

## 1.1. Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэлтэй хэрэглэгч нэвтрэх заавар

Хэрэглэгч та [www.license.mof.gov.mn](http://www.license.mof.gov.mn) сайт руу орно.


1. “НЭВТРЭХ” товчийг дарснаар Нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтрэх цонхыг дуудна. Гарч ирсэн цонхонд иргэний бүртгэлээр нэвтрэнэ.
2. Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр нууц үгээ оруулан “НЭВТРЭХ” товчийг дарна.




## 1.2. Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэлгүй хэрэглэгч нэвтрэх заавар

Хэрэглэгч [www.license.mof.gov.mn](http://www.license.mof.gov.mn) сайт руу орно.

1. Нүүр хуудсанд байх “БҮРТГҮҮЛЭХ” товчийг дарснаар Нэвтрэлтийн нэгдсэн системийн бүртгэлийн цонхыг дуудна.
2. Гарч ирсэн цонхонд өөрийн мэдээллээ үнэн зөв оруулж “I’m not a robot” чек хийнэ.
3. Бүх мэдээллийг бүрэн оруулсны дараа “БҮРТГҮҮЛЭХ” товч дарснаар таны бүртгүүлсэн цахим шуудан, болон гар утсанд нэвтрэх нэр болон нэг удаагийн нууц үг очно.




Цахим шууданд ирсэн нэвтрэх нэр болон нэг удаагийн нууц үгийг оруулж нэвтэрч системээс илгээсэн нэг удаагийн нууц үгийг заавал солих шаардлагатайг **анхаарна уу**.




### 1.3. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах байгууллагын эрх холбох тохиргоо

Хэрэглэгч тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах ААН холбохдоо **etax.mta.mn** сайтад нэвтэрч тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах ААН -ийг сонгон орно.



Дараа нь “**хэрэглэгчийн тохиргоо**” хэсэгт Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах хэрэглэгчийг сонгоно. Үйлдэл хэсэгт байрлах **ЗАСАХ** товч дээр дарна.



Хэрэглэгчийн эрх тохируулах цонхны **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ** хэсгийг сонгож хадгалснаар тухайн ААН-ийг төлөөлөн хүсэлт гаргах боломжтой болно.

Хэрэглэгч та холбогдох эрхийн тохиргоог хийснээр өөрийн нэвтрэх нэр, нууц үгээр тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах ААН дээр дарж **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМ-Д** нэвтэрнэ



## 2. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар илгээх

Сангийн яам, Гаалийн ерөнхий газраас олгож буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон шинээр тусгай зөвшөөрөл хүсч буй иргэн, хуулийн этгээдүүдийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх шатны үйл ажиллагааг ил тод байдлаар хүргэх зорилгоор хэрэглэнэ.

## 2.1 Мэдээлэл цэс

Тусгай зөвшөөрлийн хүсэлт цахимаар илгээхийн тулд хамгийн түрүүнд байгууллагын мэдээлэл шинэчлэлт хийх, мэргэжилтнүүдийн бүртгэлийг “Мэдээлэл” цэс дээр хийнэ. Ингэснээр тусгай зөвшөөрлийн цахим хүсэлтэд байгууллагын шинэчилсэн мэдээллээс цахим өргөдөл болон мэргэжилтнүүдийн анкет, мэргэжилтнүүдийн нийгмийн даатгал төлөлтийн мэдээг татна.

### Үндсэн мэдээлэл цонх

“Үндсэн мэдээлэл” цонхыг сонгоно. **МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭХ** товч дарснаар ААН болон ерөнхий захирлын мэдээллүүдийг УБЕГ-аас дуудаж харуулна. Хэрэв байгууллагын мэдээлэл зөрүүтэй бол УБЕГ-т хандаж засуулна.

Хуулийн этгээдийн мэдээлэл болон Ерөнхий захирлын мэдээлэл талбаруудад и-мэйл хаяг, цахим хуудас, ААН-ийн лого, салбарын мэдээлэл, захирлын гар утас, шууданийн хаяг зэрэг талбарт харгазах мэдээллийг гараас **ХАДГАЛАХ** товч дарна.

### Тохиргоо – Харах дэлгэцний тохиргоо

Тохиргоо товчийг дарж “Харах дэлгэцний тохиргоо” цонхыг дуудна. Тус цонхоос тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад шаардлагатай мэргэжилтэн, салбар, хэрэгцээт бичиг баримт бүртгэхийн тулд сонгож **ХАДГАЛАХ** товч дарна.

## Салбар бүртгэх

Салбар талбарыг сонгож **НЭМЭХ** товч дарна. “Салбар бүртгэх” цонхны харгалзах мэдээллүүдийг оруулж **НЭМЭХ** товч дарснаар салбарын мэдээлэл амжилттай бүртгэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн цахим систем

Энэхүү систем нь Монгол Улсын Сангийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл...

Танд амжилт хүсье.

Үндсэн мэдээлэл Салбар

+ Нэмэх

№ ААН РД Нэр

Салбар бүртгэх

ААН регистрийн №  
5100992

\* Нэр

Хаяг

\* Салбарын регистрийн №

Овог

Нэр

\* Утасны дугаар

\* Гэрчилгээний дугаар

Хаах НЭМЭХ

## Ажилтны мэдээлэл бүртгэх

Тохиргоо цонхноос “Татварын мэргэшсэн зөвлөхүүд, Гаалийн мэргэжилтнүүд, Мэргэшсэн нягтлан бодогчууд” сонгож дарна. Гарч ирсэн талбарт байх **НЭМЭХ** товч дарж “Ажилтан бүртгэх” цонхыг дуудна.

Буцах

Мэдээлэл шинэчлэх Хадгалах

Үндсэн мэдээлэл Салбар

Татварын мэргэшсэн зөвлөхүүд Гаалийн мэргэжилтнүүд Мэргэшсэн нягтлан бодогчууд

+ Нэмэх

№	Овог	Нэр	РД	Албан тушаал	Үйлдэл
---	------	-----	----	--------------	--------

Хоосон

Гарч ирсэн цонхны дээд хэсэгт мэргэжилтний регистрийн дугаарыг бичиж “**ХАЙХ**” товч дээр дарна. Хайсан регистрийн дагуу тухайн мэргэжилтний ерөнхий мэдээллийг харуулах бөгөөд **\*улаан одоор** тэмдэглэгээ хийсэн талбаруудад зохих мэдээллийг гараас оруулж **ХАДГАЛАХ** товч дарна.



Ажилтан бүртгэл

Хайж

Улс  
Монгол

Регистрийн дугаар

Ургийн овог

Овог

Нэр  
ЭНХТУЯА

Үндсэн хаяг  
УБ, Баянгол,  байр,  тоот

\* Албан тушаал  
  
 Заавал бөглөнө үү!  
 Гар утас  Ажлын утас

Цахим шуудангийн хаяг

\* Шуудангийн хаяг  
  
 Заавал бөглөнө үү!  
 \* Гэрчилгээний дугаар  
  
 Заавал бөглөнө үү!  
 \* Батламжын дугаар  
  
 Заавал бөглөнө үү!

Хаах Нэмэх

Мэргэжилтний бүртгэл амжилттай хийгдсэн бол жагсаалт хэсэгт харуулна. Тухайн бүртгэлийг засах, анкет харах, НД төлөлт харах, устгах үйлдлийг хийх боломжтой.

Үндсэн мэдээлэл Татварын мэргэшсэн зөвлөхүүд

+ Нэмэх


№	Овог	Нэр	РД	Албан тушаал	Гэрчилгээ №	Батламж №	Үйлдэл
1	Батнасан	ЭНХТУНГАЛАГ	эд82020706	Мэргэжилтэн	12-0663		✎ 👁 🗑 ✕
2	Баасансүрэн	БОЛОРЦЭЦЭГ	фв84102804	Мэргэжилтэн	14-1042		✎ 👁 🗑 ✕
3	Нацагдорж	ШИНЭ-ОД	мр86020904	Ахлах мэргэжилтэн	11-0588		✎ 👁 🗑 ✕

### САНАМЖ:

- Бүртгэсэн ажилтны регистрийн дугаараар холбогдох хөндлөнгийн байгууллагууд /УБЕГ, НББИ ын мэдээллийн сангаас шалгаж “Хүсэлт гаргах” цэс “Мэргэжилтний анкет” талбарт автоматаар татдаг тул мэдээллийг үнэн зөв оруулна.
- Тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх материалын шаардлагад дурдсан тоог хангах тооны мэргэжилтэн бүртгэнэ.


## Хэрэгцээт бичиг баримт

Тохиргоо цонхноос “Хэрэгцээт бичиг баримт” -ыг сонгож дарна. Гарч ирсэн талбараас тусгай зөвшөөрлийн хүсэлт илгээх яам, газар болон тусгай зөвшөөрлийг сонгож баримт бичгийг хавсаргана.



## 2.2 Хүсэлт гаргах

Тусгай зөвшөөрлийн шинээр авах, сунгах хүсэлт илгээхдээ “хүсэлт гаргах” цэс дарна. Тухайн цэсээс тусгай зөвшөөрлийн төрлийг сонгоно. Тусгай зөвшөөрлийн төрөл, шинээр эсвэл сунгах эсэхээс хамаарч “бүрдүүлэх материал”, “нөхцөл шаардлага”, “байнгын шалгуур”, “түгээмэл асуулт хариулт” хэсгүүд ялгаатай байна.



## Бүрдүүлэх материалууд

Тусгай зөвшөөрлийн төрөл бүрт харагдах [Бүрдүүлэх материалууд](#) товч дарж тухайн тусгай зөвшөөрөлд шаардагдах бүрдүүлэх материалын мэдээллийг авах боломжтой. Тусгай зөвшөөрлийн төрөл, шинээр эсвэл сунгах эсэхээс хамаарч “бүрдүүлэх материал”, “нөхцөл шаардлага”, “байнгын шалгуур”, “түгээмэл асуулт хариулт” хэсгүүд ялгаатай байна.

Бүрдүүлэх материалууд

Бүрдүүлэх материалууд
  Нөхцөл шаардлага
  Байнгын шалгуур
  Түгээмэл асуулт хариулт

Шинээр авах

Нэр	Аргачлал	Тайлбар
Үүсгэн байгуулах хурлын шийдвэр	Файл хавсаргах	<a href="#">i</a>
Хуулийн этгээдийн дүрэм	Файл хавсаргах	<a href="#">i</a>
Үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэл, программ хангамжтай байх	Файл хавсаргах	<a href="#">i</a>
Үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачлал, арга зүйгээр хангагдсан байх	Файл хавсаргах	<a href="#">i</a>
Зөвлөх үйлчилгээний ажлын баримтыг хадгалах зориулалтын архивтай байх	Файл хавсаргах	<a href="#">i</a>
Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх	Файл хавсаргах	<a href="#">i</a>

Бүрдүүлэх материалууд цонх дараах мэдээллүүд байна. Үүнд:

№	Талбар	Тайлбар
1	Бүрдүүлэх материалууд	Тухайн тусгай зөвшөөрөлд шаардлагатай бүрдүүлэх материалын жагсаалт
2	Нөхцөл шаардлага	Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад анхан шатны шаардлагуудын жагсаалт
3	Байнгын шалгуур	Тусгай зөвшөөрөл бүрт тохирсон байнгын шалгуурын мэдээлэл
4	Түгээмэл асуулт хариулт	Иргэд, ААН-үүдэд зориулсан асуулт хариултын мэдээллийн сан

### Хүсэлт гаргах

Тухайн тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд шаардлагатай материалуудыг бүрэн бүрдүүлсний дараа [+ Хүсэлт гаргах](#) товч дарна. Гарч ирсэн цонхонд “нөхцөл, шаардлага”-ыг системээс шалгуур ажиллаж, автоматаар дуудна. СУМ дарж дэлгэрэнгүй мэдээллийг шалгана. Нөхцөл шаардлагууд нь хөндлөнгийн мэдээнээс татдаг тул алдаатай мэдээлэл байвал тухайн байгууллагуудад хандаж засуулна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл

ААН нэр:

Нөхцөл, шаардлага

- Өргөдөл хүсэлт
  - > Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - > Аж ахуй нэгжийн татварын өргүй болохыг нотолсон татварын тодорхойлолт
  - > Үүсгэн байгуулагч нь татварын мэргэшсэн зөвлөх байх
  - > Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн анкет

Шинээр авах

Хэрэв шалгуур хангахгүй бол холбогдох тайлбарыг **Улаанаар** харуулна. Хүсэлт гаргагч холбогдох байгууллагуудад мэдээллээ засуулснаар цахим тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах боломжтой болно.

Нөхцөл, шаардлага

- > Өргөдөл хүсэлт
- > Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- > Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байх
- > Захирал, партнер нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Институтээс зохих зөвшөөрөл авсан байх

Захирал Институтээс зохих зөвшөөрөл/Аудиторын батламж/ аваагүй байна.

- > Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт хувьцаа эзэмшлийн гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшдэг байх
- > Хоёроос доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх

2-с багагүй ажилтан бүртгэлтэй байх, Мэргэшсэн нягтлан бодогчдийн регистрийн дугаар олдсонгүй, Бүртгэсэн регистрийн дугаар олдсонгүй.

- > Аудитын хуулийн этгээд нь салбартай байж болох бөгөөд салбарт үндсэн орон тооны нэгээс доошгүй аудитортай байна
- > Институтийн зөвшөөрөл

ММНБИ-ийн системээс мэдээлэл олдохгүй байна

Шинээр авах

Нөхцөл, шаардлагуудыг бүгд шалгуур хангасан байвал **Шинээр авах** товч дарна. Гарч ирсэн цонхонд нөхцөл, шаардлагууд; бүрдүүлэх материалууд; шийдвэрлэлтийн явцыг харуулна.

< Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл **Бөгөөд байгаа**

ААН нэр: Монголтас ТМЗ ХХК

Нөхцөл, шаардлага

- > Өргөдөл хүсэлт
- > Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- > Аж ахуй нэгжийн татварын өргүй болохыг нотолсон татварын тодорхойлолт
- > Үүсгэн байгуулагч нь татварын мэргэшсэн зөвлөх байх
- > Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн анкет

Сүүлийн шийдвэрлэлт **Үүсгэж** 2021-09-10 17:56:48

ЭНХБИЛЭГ - Хүсэлт гаргах үйлдлийг эхлүүлсэн


Хүсэлтийн түүх харх

1 Шийдвэрлэлт


- Мэргэжилтэн Бямбажав
- Мэргэжилтэн Бямбажав

- > Үүсгэн байгуулах хурлын шийдвэр **Файл хавсаргах**
- > Хуулийн этгээдийн дүрэм **Файл хавсаргах**
- > Үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэл, программ хангамжтай байх **Файл хавсаргах**
- > Үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачлал, арга зүйгээр хангагдсан байх **Файл хавсаргах**
- > Зөвлөх үйлчилгээний ажлын баримтыг хадгалах зориулалтын архивтай байх **Файл хавсаргах**
- > Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх **Файл хавсаргах**


Бүрдүүлэх материалыг оруулахдаа урд байрлах **СУМ** дарж файл оруулах цонхыг дуудна. Файл оруулахдаа **Файл оруулах** товч дарж хуулах файлын замыг зааж өгнө.



Хуулсан файлаа **БАТАЛГААЖУУЛАХ** товч дарж **ТИЙМ** үйлдэл хийснээр тухайн файл амжилттай хавсаргагдана. Баталгаажуулалт хийхээс өмнө хуулсан файлаа татаж авах, устгах боломжтой.



Бүрдүүлэх материалыг баталгаажуулалт хийсэн тохиолдолд **НОГООН** өнгөөр ялгарч харагдана.



Бүх бүрдүүлэх материал ногоон буюу баталгаажуулалт хийсний дараа хүсэлт илгээх товч идэвхжнэ. Тайлбар талбарт холбогдох тайлбарыг бичиж, шаардлагатай бол файл хавсарган **ХҮСЭЛТ ИЛГЭЭХ** товч дарна.

Сүүлийн шийдвэрлэлт **Үүсгэн** 2021-09-10 17:56:48

ЭНХБИЛЭГ - [Хүсэлт гаргах үйлдлийг эхлүүлсэн] Хүсэлтийн түүх харах

Хүсэлт илгээх

\* Тайлбар:

> Үүсгэн байгуулах хурлын шийдвэр	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>
> Хуулийн этгээдийн дүрэм	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>
> Үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгсэл, программ хангамжтай байх	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>
> Үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачлал, арга зүйгээр хангагдсан байх	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>
> Зөвлөх үйлчилгээний ажлын баримтыг хадгалах зориулалтын архивтай байх	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>
> Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх	Файл хавсаргах <input type="button" value="↓"/>

### 2.3 Тусгай зөвшөөрлийн хүсэлтийн мэдээлэл


Хэрэглэгчид тусгай зөвшөөрлийн хүсэлт амжилттай илгээгдсэн нөхцөлд системд бүртгүүлсэн гар утасны дугаар болон цахим шууданд мэдээлэл дараах мэдээллүүдийг хүргүүлнэ. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн хүсэлт амжилттай илгээгдсэн
- Тусгай зөвшөөрлийн хүсэлт цуцлагдсан нөхцөлд
- Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлөх тухай

**Гар утсанд:**




**Цахим шуудангаар:**




### 3. Хүсэлтийн түүх


Тусгай зөвшөөрлийн хүсэлт цахим системээр илгээсэн хүсэлтийн явцыг хянах, мэргэжилтнүүдийн бичсэн мэдэгдэл, хүсэлтийн хариу харах, тусгай зөвшөөрлийн төлбөрийн нэхэмжлэх төлөх зориулалтаар ашиглана.

Хэрэглэгч системийн **Хүсэлтийн түүх** цэсэд нэвтэрч тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын төрлийг сонгоно.




**НЭМЭХ** товч дарж хүсэлт гаргагчийн мэдээлэл, хүсэлтийн төрөл, илгээсэн огнооны мэдээллийг харна. **СУМ** товч дарснаар дэлгэрэнгүйгээр илгээсэн материалын жагсаалт, мэргэжилтнүүдийн бичсэн мэдэгдлийг, тусгай зөвшөөрлийн нэхэмжлэхийн мэдээллийг харна.






Хэрэглэгч **ХҮСЭЛТИЙН ТҮҮХ** товч дарж өөрийн нэвтрэлтэд холбосон бүх хүсэлтийн явцыг харна.



### 3.1 Тусгай зөвшөөрлийн илгээсэн хүсэлтийн төлөв

Хэрэглэгчийн илгээсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг мэргэжилтэн хянаж шалгаад буцаасан, татгалзсан, зөвшөөрсөн эсэхийг “Хүсэлтийн түүх” цэсээс шалгана. Мөн энэ тухай мэдэгдэл системд бүртгэлтэй гар утасны дугаар, цахим шуудангаар хэрэглэгчдэд очно.

Мэргэжилтэн хүлээн авч шийдвэрлэлтийн явцад байгаа тохиолдолд:



Төлбөр төлөгдөж баталгаажсан хариу:



Зөвшөөрлийн нэр	Төрөл	Төлөв	Эхлэх огноо	Дуусах огноо
Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Байгууллагаар	Хүчинтэй зөвшөөрөл	2021-09-13 11:16:27	2024-09-13 11:16:27
Хүсэлт гаргасан хэрэглэгч	Төрөл	Хүсэлтийн төлөв	Илгээсэн огноо	
МӨНХ-ЭРДЭНЭ	Шинээр авч	Баталгаажсан	2021-07-28 17:24:07	

### 3.2 Улсын тэмдэгтийн хураамж төлөх нэхэмжлэх, төлөлт

Хэрэглэгчийн гар утас болон цахим шууданд улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай мэдэгдэл ирнэ. Тухайн нэхэмжлэл нь “Цахим татварын систем” болон “Тусгай зөвшөөрлийн цахим систем”-үүдэд очно.

Хэрэглэгч “Хүсэлтийн түүх” цэсэд нэвтэрч “Улсын тэмдэгтийн хураамжын нэхэмжлэх” мэдэгдэл харагдана. байх **ТӨЛӨХ** товч дарж төлбөрийн нэхэмжлэхийн **QR code**-ыг дуудаж утаснаасаа **QPAY** үйлчилгээ ашиглан төлөх боломжтой.

Шалгуур ажиллаж байна  
Нөхцөл шаардлага хангасан эсхийг дахин шалгаж байна.

- > Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулиар
- > Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байх
- > Захирал, партнер нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй. Институтээс зохих зөвшөөрөл авсан байх
- > Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт хувьцаа эзэмшлийн гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшдэг байх
- > Хоёроос доошгүй үндсэн орон тооны хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх
- > Аудитын хуулийн этгээд нь салбартай байж болох бөгөөд салбарт үндсэн орон тооны нэгээс доошгүй аудитортай байна
- > Институтийн зөвшөөрөл

Сүүлийн шийдвэрлэлт **Баталгаажуулсан** 2021-09-13 11:16:27


БҮЯНХИШИГ **ХХК** нь цэвэр системийн нөхцөл шаардлага хангаж, тэмдэгтийн хураамжаа төлөв.

Улсын тэмдэгтийн хураамжын нэхэмжлэх


Дугаар : 2210901070709    Үүсгэн огноо : 2021-09-13 18:37:51    Төлөх дүн : 500.000.00 MNT

**Төлөх**

Тэмдэгтийн хураамжийг **QPAY**-аар төлөх бол **ТӨЛӨХ** товч дарж төлбөрийн нэхэмжлэхийн **QR code** дуудаж утаснаасаа **QPAY** үйлчилгээ ашиглаж төлнө.



Хэрэв QRAY үйлчилгээ ашиглах боломжгүй бол нэхэмжлэхийн дугаараар арилжааны банкнд очиж төлөх боломжтой. Мөн тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж төлөх нэхэмжлэх “Цахим татварын систем”д /e.tax.mta.mn/ үүснэ.



Хэрэглэгчийн улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөлтийг мэргэжилтэн шалгаж баталгаажуулснаар “Хүчинтэй зөвшөөрөл” цэсэд нэвтэрч цахим гэрчилгээний QR кодыг авна.